| 210302 | Түлш, халаалт | 33,264,000.00 | 33,264,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,817,000.00 | 9,817,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,081,800.00 | 1,081,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,578,500.00 | 6,578,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,068,700.00 | 2,068,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,000.00 | 88,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,560,000.00 | 13,560,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,460,000.00 | 12,460,000.00 |
| 210602 | Тавилга | | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | - |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,218,400.00 | 2,218,400.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,218,400.00 | 2,218,400.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,714,600.00 | 1,714,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 529,200.00 | 529,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 362,200.00 | 362,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 176,900.00 | 176,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 378,700.00 | 378,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 37,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 65,000.00 | 65,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,500,000.00 | 13,500,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,000,000.00 | 13,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 84,717,000.00 | 84,717,000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 21,299,000.00 | 21,299,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 21,299,000.00 | 21,299,000.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 63,418,000.00 | 63,418,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 24,206,300.00 | 24,206,300.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 39,211,700.00 | 39,211,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 404,304,100.00 | 404,304,100.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 404,304,100.00 | 404,304,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 404,304,100.00 | 404,304,100.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 22.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 7.00 | 7.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 9.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1.00 | 1.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **23.00** | **22.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10.00 | 9.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 2.00 | 2.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.00 | 6.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11,919,852.00** | **10,984,044.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,919,852.00** | **10,984,044.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11,739,852.00 | 10,984,044.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,490,303.00 | 1,860,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,490,303.00 | 1,530,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 330,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| **2105** | **Нормативт зардал** | 730,000.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 730,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 160,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 160,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,519,549.00 | 8,964,044.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,519,549.00 | 8,964,044.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **180,000.00** | - |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 180,000.00 | |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 11,919,852.00 | 10,984,044.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11,919,852.00 | 10,984,044.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,919,852.00 | 2,530,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 8,454,044.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |

| | | | |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Алтанцөгц сумын Засаг даргын тамгын газар нь төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага. ЗДТГ зорилгыг “Төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй болгох“ гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Төрөөс иргэдэд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, иргэн төвтэй төрийн үйлчилгэний жилийн хүрээнд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Алтанцөгц сумын ЗДТГ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын 2022 оны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг зохих журмын дагуу хөтлөж, анхан шатны баримт материалыг зохих журмын дагуу бүрдүүлж, бараа материалын тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаа шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй *гэж* үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанцөгц сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2020 оны 11 сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанцөгц сумын ЗДТГ 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 272.2 сая төгрөгөөр буюу 29.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | |
| Авлага | - | 537.00 | |
| Урьдчилгаа | - | - | |
| Бараа материал | 7,767.00 | 21,967.00 | -14,200.00 |
| Үндсэн хөрөнгө | 914,928.90 | 1,172,403.20 | -257,474.30 |
| **Нийт хөрөнгө** | **922,695.90** | **1,194,907.20** | -272,211.30 |
| Өр төлбөр | - | - | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 922,695.90 | 1,194,907.20 | -272,211.30 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **922,695.90** | **1,194,907.20** | -272,211.30 |

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

ЗДТГ нь оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй байна.Авлагын үлдэгдлийг 0.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Бараа материалын үлдэгдэл өнгөрсөн оны үлдэгдлээс 14.2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Төсвийн хөрөнгөөр 25.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, үнэ төлбөргүй 9.0 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, оны эцэст 22.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.Акталсан бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө 257.5 сая төгрөгөөр өссөн.Төсвийн хөрөнгөөр 7.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан. Бусад эх үүсвэрээр буюу хөрөнгө оруулалтаар 326.9 сая

төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсны 200.0 сая төгрөг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах засмал замын газрын тэгшилгээ байна.

Үндсэн хөрөнгөд 84.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан. Акталсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Үр дүнгийн тайланд хөрөнгийн орлого хэсэгт дуусаагүй барилга байгууламжийг орлого авч бүртгэсэнтэй холбоотой 272.2 сая төгрөгийн үр дүнтэй гарч, Засгийн газрын хувь оролцоо данс 272.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 308.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 308.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 96.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 404.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт 2 удаа тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 404.3 сая сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 404.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 404.3 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 255,612.30 | 255,612.30 | - | 100.00 |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 50,974.80 | 50,974.80 | - | 100.00 |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 39,211.70 | 39,211.70 | - | 100.00 |
| 4 | Сонгуулийн үр дүнгээр | 24,206.30 | 24,206.30 | - | 100.00 |
| 5 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 10,000.00 | 10,000.00 | - | 100.00 |
| 6 | Улсын их баяр наадам | 3,000.00 | 3,000.00 | - | 100.00 |
| 7 | ОНХС-итгэлцүүрээр олгох | 21,299.00 | 21,299.00 | - | 100.00 |
| | **Дүн** | **404,304.10** | **404,304.10** | - | 100.00 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Алтанцөгц сумын ЗДТГ нь тайлант онд 10.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулсан байна. Үүнд: Хангамж бараа материалын зардалд 1.8 сая төгрөгийг, томилолт зочны зардалд 0.2 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 8.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Алтанцөгц сумын ЗДТГ нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/13 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтанцөгц сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 458.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Хугацаа хоцроож оруулсан мэдээлэл байхгүй. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан тушаал шийдвэрүүдийг хавсаргаагүйгээс шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 87.5 хувьтай гарсан байна.

Төсөв мөнгөтэй холбоотой гарсан шийдвэрүүдийг Шилэн дансны цахим худсанд мэдээлж байхыг зөвлөмж болголоо.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой залруулсан алдаа гараагүй.

Аудитын дүнгээр төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт*:

Шилэн дансны цахим хуудасны мэдээллийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд төсөв, мөнгө, хөрөнгөтэй холбоотой тушаал 12 шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 87.5 хувьтай байна.

*1.2.Өгсөн зөвлөмж*:
Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |

| **Дүн** | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд байршуулахгүй орхигдуулсан | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| **Дүн** | **1** | **0 .0** | | | | | **1** | **0 .0** |
| Төрийн хэмнэлтийн тухай  хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **0 .0** | | | | | **1** | **0 .0** |